



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№194 /404/

2022.10.28

Цаг үе, үйл явдал

ТЭТГЭВЭР БОЛОН ЧӨЛӨӨНД ГАРСАН АХЛАГЧИДТАЙ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ



ГЭРЭЛ ЗУРГИЙГ Х.УНДАРМАА

“Монгол ахлагч мөнхийн холбоо” НҮТББ-аас Зэвсэгт хүчин хэмээх их айлыг түшицлэн яваа ахлагч нарынхаа амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, түүнд холбогдох эрх зүйн орчныг сайжруулах, уг байгууллагынхаа үйл ажиллагааг бие бүрэлдэхүүнд танилцуулах зорилготой анхдугаар уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтад ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Н.Баасан, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн ахлагч, тэргүүн ахлагч Н.Баттөмөр, Барилга-инженерийн цэргийн ахлагч, тэргүүн

ахлагч Б.Эрдэнэчулуун, “Монгол ахлагч мөнхийн холбоо” НҮТББ-ын удирдах зөвлөлийн дарга бэлтгэл тэргүүн ахлагч Д.Энхбаяр, гүйцэтгэх захирал Д.Анхбаяр нарын тэргүүтэй Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын ахлагч, бэлтгэлд болон чөлөөнд байгаа ахмад дайчид оролцоо.

Уулзалтыг нээж “Монгол ахлагч мөнхийн холбоо” НҮТББ-ын гүйцэтгэх захирал Д.Анхбаяр намрын адаг сарын шинийн гуравны Балжинням, Дашням давхацсан билэгт сайн өдөр Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын их танхимыг дүүргэн хуран чуулсан

ахлагч нар, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчдадаа баярлаж талархсанаа илэрхийлээд анхдугаар уулзалт нээснийг мэдэгдсэн юм.

Үргэлжлүүлэн “Монгол ахлагч мөнхийн холбоо” НҮТББ-ын удирдах зөвлөлийн дарга бэлтгэл тэргүүн ахлагч Д.Энхбаяр эл байгууллагынхаа зорилго, зорилт, ирээдүйн үйл ажиллагааны төлөвлөгөө, зарчмыг нийт бие бүрэлдэхүүнд танилцууллаа. Тус байгууллага нь 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр байгуулагдсан бөгөөд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудаас бэлтгэл,

чөлөөнд гарсан болон одоо алба хааж байгаа ахлагч нар тэдний ар гэрийнхэн, өрх толгойлсон аав, ээж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, залуучуудын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх түүнд холбогдох хууль, эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгаа, дүн шинжилгээ хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тэтгэвэрт гарсны дараагаар энгийн мэргэжил эзэмшихэд тусалцаа үзүүлэх, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хамтран ажиллах чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой аж.

Түүнчлэн ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Н.Баасан “Монгол ахлагч мөнхийн холбоо” НҮТББ-ын анхдугаар зөвлөлдөх уулзалтын хүрээнд бэлтгэл болон одоо алба хааж байгаа ахлагч нарынхаа нийгмийн асуудлыг сонсож, санал солилцон төрийн цэргийн байгууллагуудын удирдлагуудад асуудлыг танилцуулах, түүнд холбогдох санал зөвлөмжийг боловсруулж хүргүүлэх, шийдвэрлүүлэх, цаашид салбарын эрх зүйн орчныг сайжруулах талаар санал хүсэлтээ солилцоо. Тус байгууллагын хувьд зөвхөн салбарын эрх зүйн орчныг сайжруулах бус өөр олон ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана гэдгийг онцоллоо.

Мөн энэ үеэр ЦДБЭЧ-ын уран бүтээлчид хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгч, ахмадуудад зориулсан хүндэтгэлийн тоглолтоо өргөн барьсан юм.

Ө.НАСАНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 9	☁ -3


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 36	☁ 24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,412	3,420
EUR	3,415	3,430
CNY	467.50	473
RUB	52.80	53.20
JPY	23.20	23.50
KRW	2.45	2.48

ЗУРХАЙ



2022.10.28 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 3

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР
НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХ БАР ӨДӨР

Үс засуулбал:

Эд мал баялаг төгөлдөр болно

Наран ургах, шингэх:

07.30-17.42

Барилдлага:

Шид

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

АТТАШЕ НАРТ ЗОРИУЛСАН СОЁЛЫН АРГА ХЭМЖЭЭ БОЛЛОО



Эдгээр өдрүүдэд Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-нд “Монголын Соёлын долоо хоног” сэдэвт арга хэмжээ зохион байгуулагдаж байна. Энэ хүрээнд 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Бээжинд суугаа гадаад орны ЭСЯ-

дын Батлан хамгаалахын атташе нарт зориулан соёлын арга хэмжээг зохион байгуулав.

Арга хэмжээг Батлан хамгаалахын атташе, хурандаа М.Ганбат нээн үг хэлж, Монголын соёлын талаар танилцууллаа. Энэ



удаагийн арга хэмжээнд 40 орчим орны Батлан хамгаалахын атташе нар гэргийтэйгээ хүрэлцэн ирж оролцлоо.

Энэ үеэр Монголын нэрт уран бүтээлч, уран барималч Б.Дэнзэнгийн уран зургийн үзэсгэлэн, Морин

хуур, хөөмий, Монголын үндэсний их театрын уран бүтээлчдийн мэндчилгээ, “Цам”-ын бүжиг, “Үндэсний болон ноолууран хувцас”-ны загварын үзүүлбэр зэргийг дэлгэгдэж олны хүртээл болсон юм.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 634,121,317

Эдгэрсэн

Нийт: 613,153,839

Нас барсан

Нийт: 6,587,579

АЖИЛЛАГААНЫ ӨМНӨХ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ДУУСЛАА



БНӨСУ-д явагдаж байгаа “UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний XII ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн ажиллагааны өмнөх сургалтаа хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс 10 дугаар сарын 23-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн районд амжилттай зохион байгуулж, дуусгалаа.

Цэргийн баг ажиллагааны өмнөх сургалтыг “Нэг бүрийн бэлтгэл”, “Салбарын жигдрэлт”, “Цэргийн багийн жигдрэлт” гэсэн гурван шатаар зохион байгуулж, цэргийн алба хаагч нэг бүрийн бэлтгэлжилт, салаа, рот, багийн жигдрэлтийг хангасан юм.

Ажиллагааны өмнөх сургалтаар бие бүрэлдэхүүнд сэтгэл зүй, бие бялдрын тэсвэр хатуужлыг олгох, мэдлэг, ур чадвар,

дадлыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт, харилцан уялдаа бүхий арга хэмжээнүүдийг зохион байгуулж, ажилласан нь цэргийн багийг богино хугацаанд жигдрүүлэх, бие бүрэлдэхүүний нөхөрсөг, нийтэч байдлыг төлөвшүүлэхэд үр дүн өгсөн байна.

Мөн шат бүрийн сургалтыг мэдээлэл, сурталчилгаа, соёл, сэтгэл зүйн хангалтын

ажил, арга хэмжээтэй уялдуулан, цэргийн алба, материал, техникийн хангалтын ажилтай нийцүүлэн зохион байгуулснаар ажиллагааны өмнөх сургалт амжилттай явагдах нөхцөл бүрдсэн.

Цаашид НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох хүсэлтэй байгаа цэргийн алба хаагчид Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарт явагдаж байгаа цэргийн сургалтын

арга хэмжээнд идэвх, санаачлагатай оролцож, өөрийгөө хөгжүүлэн, хэлний болон бусад мэдлэг, ур чадвар, дадлыг нэмэгдүүлснээр ажиллагааны өмнөх сургалт, ажиллагааны үеийн үүрэг гүйцэтгэлт хялбар байх болно гэдгийг үүгээр уриалж байна.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

“ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН МАНЛАЙЛАЛ” СУРГАЛТААР ...



Энэ сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний заах аргын

цугларалтыг “Удирдах БХЯ, ЗХЖШ-ын болон Удирдлагын академийн Сургалтын танхим, “Их тэнгэр” цогцолборт шинэлэг

Удирдах БХЯ, ЗХЖШ-ын болон Удирдлагын академийн Сургалтын танхим, “Их тэнгэр” цогцолборт шинэлэг

хэлбэрээр зохион байгуулсан юм.

Уг сургалтыг нээж ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах үг хэлсэн бөгөөд сургалтад оролцогчдод амжилт хүслээ. Мөн энэ үеэр ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор “Цэргийн сургалт бэлтгэлд удирдлагын манлайллын нөлөөлөл, гадаад улс орнуудын туршлага, сургамж” сэдвээр лекц уншиж, ерөнхий мэдээллийг өглөө.

Үүний дараа сургалтад оролцогчид дөрвөн бүлгийн зохион байгуулалтад орж, хичээлд хамрагдсан юм. Энэ үеэр Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч бригадын генерал Б.Баатар, Кибер аюулгүй байдлын

цэргийн командлагч бригадын генерал Д.Баасандамба, Агаарын цэргийн командлагч Сургалтын ахлах офицер дэд хурандаа О.Амарсанаа, ҮБХИС-ийн Сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал хурандаа Б.Энхзоргол, Аюулгүй байдлын дээд сургуулийн багш Б.Дарханцэцэг нар “Шийдвэр гаргах ур чадвар”, “Харилцааны ур чадвар”, “Хувь хүний EQ-г зөв залах”, “Багаар ажиллах” зэрэг сэдвээр сургалтыг онол, харилцан ярилцлага, дадлага, багийн тоглолтын арга зэрэг

сонирхолтой хэлбэрээр явуулсан юм.

Энэхүү сургалтын төгсгөлд Умард Атлантын гэрээний байгууллага (NATO)-аас Монгол Улсын Батлан хамгаалах боловсролыг хөгжүүлэх “Deer Mongolia” хөтөлбөрийн хүрээнд “Цэргийн манлайллын сургалт”-ыг зохион байгуулж буй сургагч багш нарын хамтаар нэгдсэн хэлэлцүүлгийг зохион байгуулж, харилцан ярилцлага өрнүүлэн нэгдсэн ойлголтод хүрлээ.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №12

НУМ

Нум зурлагын бүтэц, зөв бичих ёсыг 5 дугаар хичээлээр товч үзсэн билээ. Дараалан орсон хоёр нумын эхнийхийг жижиг, дараагийнхыг үндсэн хэмжээгээр нь, зайгүй нийлүүлж бичдэг.

Энэ нь цэвэр хичээнгүй сайхан бичиж сурахын үндэс болмуй.

Дармалаар:

Бичмэлээр:

ᠰᠤᠰᠤ

ᠰᠤᠰᠤ

ᠰᠤᠰᠤ



Талархал



Зэвсэгт хүчний 124 дүгээр ангиас гавьяаны амралтдаа гарсан бидний хүсэлтийг хүлээн авч хүнд хэцүү цаг үед хандивын халуун гараа сунган охины минь эмчилгээний төлбөрийг бүрдүүлэхэд сэтгэлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа ЗХЖШ, Цэргийн командлалууд болон харьяа анги байгууллагууд нийт цэргийн албан хаагчдадаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Та бүхний халуун сэтгэл, дэмжлэг тусламжийн ачаар эхний хагалгааны зардал бүрдсэн тул 11 сарын 3-нд бид Энэтхэг улсыг зорин нисэх гэж байна. Мөн бидний тухай мэдээллийг олон түмэнд хүргэж тусалсан Соёмбо редакцын хамт олон болон Хуурай замын цэргийн командлагч хэвлэлийн төлөөлөгч ахмад Д.Болормаад баярлаж талархсанаа илэрхийлж байна.

Монгол цэргийн сүлд хийморь үүрд мандан бадрах болтугай.

Та бүхнийг хүндэтгэсэн: Бэлтгэл а/а Ш.Баттүвшин а/ч Э.Чинтунгалаг